230001	Эргэж төлөгдөх зээл	130,649.7	-
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,894,132.1</b>	<b>1,730,066.9</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,087,341.0</b>	<b>1,074,701.3</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,019,697.9	1,007,058.2
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	67,643.1	67,643.1
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>648,140.9</b>	<b>591,386.0</b>
320001	Орон нутгийн төсвөөс	648,140.9	591,386.0
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>17,920.7</b>	<b>13,362.1</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,920.7	13,362.1
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>140,729.5</b>	<b>50,617.4</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,537.0	49,569.5
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,047.9
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	88,192.5	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	103,817.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	158,771.7
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>824</b>	<b>966</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6</b>	<b>6</b>
610001	Төсвийн байгууллага	6	6
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>102</b>	<b>102</b>
620001	Удирдах ажилтан	10	23
620002	Гүйцэтгэх ажилтан	53	46
620003	Үйлчлэх ажилтан	31	25
620004	Гэрээт ажилтан	8	8
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>429</b>	<b>429</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>285</b>	<b>285</b>
630001	Төрийн өмчит ЕБС	285	285
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>144</b>	<b>144</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	144	144
<b>64</b>	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	<b>185</b>	<b>327</b>
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	185	327
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>102</b>	<b>102</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	31	32
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСҮ)	4	4
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	13	13
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	30	29
650010	Гэрээт ажилтан	9	9
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>205,973.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>205,973.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>180,430.1</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>20,135.0</b>
210101	Үндсэн цалин	3,200.7
210102	Нэмэгдэл	16,934.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,922.1</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,922.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,518.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	720.0
210303	Цэвэр, бохир ус	17,798.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,999.4</b>
210401	Бичиг хэрэг	772.3
210402	Тээвэр, шатахуун	4,615.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	110.0
210404	Ном, хэвлэл	916.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,585.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>103,055.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,841.0
210502	Хоол, хүнс	3,214.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,445.7</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,445.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,355.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,550.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,805.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,543.5</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>22,400.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,400.0
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,143.5</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,143.5
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>206,306.7</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>206,306.7</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,274.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,737.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	152,295.5
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>333.1</b>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	333.1

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга Л.Оч танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орлогын данстай холбоотой боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 15 -аас 2022 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Мөнхбамбар гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 02/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сум орон нутгийн хөгжил дэвшлийг хангаж, төрийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг иргэн бүрд ил тод, жигд хүртээмжтэй хүргэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Сумын нийгэм эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого зохицуулалтаар хангах
- Сумын нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад чиглэсэн бодлого зохицуулалтаар хангах
- Иргэдэд үзүүлж буй төрийн байгууллагын үйлчилгээний ил тод, нээлттэй байдал, чанар үр нөлөөг дээшлүүлэх
- Төрийн албан хаагч нарын ур чадварыг дээшлүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, нягтлан бодох бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдахгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрэх магадлалтай байна.

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2021 онд үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

### 3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 2,817.8 сая төгрөгийн зардлын 1 хувь буюу 28.1 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 234.6 сая, эцсийн үлдэгдэл 391.4 сая төгрөг болж, 156.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	2.9	2.9	0.0	0.7
Банканд байгаа бэлэн мөнгө	0.1	0.0	-0.1	0.0
Төрийн сангийн харилцах	231.7	388.5	156.8	99.3
<b>Дүн</b>	<b>234.6</b>	<b>391.4</b>	<b>156.8</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 391.4 сая төгрөгийн 388.5 сая нь төрийн сангийн харилцах дансанд, 2.9 сая нь байгууллагын /ЭЭС/ кассад байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийн 133.3 сая төгрөг буюу 34.3 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, 18.3 сая төгрөг буюу 4.7 хувийг ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт, 7.6 сая төгрөг буюу 2.0 хувийг эрүүл мэндийн төвийн харилцах дансны үлдэгдэл, 36.5 сая төгрөг буюу 9.4 хувь байгууллагуудын жилийн эцсийн харилцахын үлдэгдлийг нэгдсэн дансанд төвлөрүүлсэн, 119.4 сая төгрөг буюу 30.7 хувь төрийн сангийн харилцахын оны эхний зарцуулагдаагүй үлдэгдэл, төлөвлөснөөс давсан татварын болон татварын орлого 73.4 сая төгрөг буюу 18.9 хувийг тус тус эзэлж байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 133.4 сая, эцсийн үлдэгдэл 136.4 сая төгрөг болж, 3.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	5.4	52.5	47.1
Хувь хүмүүсээс авах авлага	128.0	83.9	(44.1)
<b>Дүн</b>	<b>133.4</b>	<b>136.4</b>	<b>3.1</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн авлага 78.9 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 50.1 сая, бусад байгууллага, хувь хүнээс авах авлага 7.4 сая төгрөг байна. Авлагын дансны үлдэгдлийн 58% нь сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 161.1 сая, эцсийн үлдэгдэл 174.3 сая төгрөг болж, 13.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	1.3	0.4	-0.9
Эм боох материал	23.1	43.4	20.3
Бичиг хэргийн материал	2.7	3.1	0.4
Аж ахуйн материал	111.3	120.3	9.0
Сэлбэг хэрэгсэл	13.3	13.1	-0.2
Түлш тослох материал	9.1	2.9	-6.2
Хүнсний материал	1.7	4.0	2.3
Бусад хангамжийн материал	6.7	25.9	19.2
Мал амьтад	5.1	40.1	35.1
<b>Дүн</b>	<b>174.3</b>	<b>253.2</b>	<b>78.9</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 253.2 сая төгрөгийн үлдэгдлийн 47.5 хувийг аж ахуйн материал эзэлж байгаа бөгөөд сэлбэг хэрэгсэл бусад хангамжийн материал, эм боох материал, мал амьтдын үлдэгдэл гол нөлөөлж байна. Мөн бараа материалын үлдэгдлийн эм 8.3 хувийг Эргэлтийн эмийн сан, 13.8 хувийн Засаг даргын Тамгын газар, 16.7 хувийг Хүүхдийн цэцэрлэг, 24.7 хувийг Эрүүл мэндийн төв, 28.1 хувийг Ерөнхий боловсролын сургууль, 8.4 хувийг Соёлын төв зэрэг байгууллагууд эзэлж байна.

#### Аудитын илрүүлэлт:

Хоолны зардлаас хэмнэгдсэн хөрөнгө нь төсвийн хэмнэлтэд тооцогдоогүй бөгөөд төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, 3.2 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлсөнд төлбөрийн акт тогтоов. /ЕБС, Цэцэрлэг/

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,797.6 сая, эцсийн үлдэгдэл 2,889.5 сая төгрөг болж, 91.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	1,652.2	1,620.7	-31.6
Тээврийн хэрэгсэл	321.1	281.0	-40.1
Машин тоног төхөөрөмж	263.5	285.3	21.8
Тавилга эд хогшил	157.5	153.5	-4.0
Номын фонд	8.0	11.0	3.0
Бусад үндсэн хөрөнгө	365.2	508.1	142.8
Программ хангамж	2.5	2.5	0.0
Бусад биет бус хөрөнгө	27.4	27.4	0.0

<b>Дүн</b>	<b>2,797.6</b>	<b>2,889.5</b>	<b>91.9</b>
------------	----------------	----------------	-------------

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 15.7 сая, Эрүүл мэндийн төв, Засаг даргын Тамгын газарт, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгт ОНХСан, дээд шатын төсөв захирагч нараас үнэ төлбөргүй 172.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба үндсэн хөрөнгө нийт 188.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв. /ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, ЗДТГ/

**3.5.5 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 19.7 сая, эцсийн үлдэгдэл 6.4 сая төгрөг болж, 13.3 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	19.7	6.4	-13.3	100.0
<i>Ажилчидтай холбогдсон өглөг</i>	1.9	0.0	-1.9	0.0
<i>Байгууллага төлөх өглөг</i>	12.4	6.3	-6.1	99.0
<i>Хувь хүмүүст төлөх өглөг</i>	5.4	0.06	-5.4	1.0
<b>Нийт дүн</b>	<b>19.7</b>	<b>6.4</b>	<b>-13.3</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст байгууллагад төлөх өглөг 6.3 сая, хувь хүнд өгөх өглөг 0.06 сая нийт 6.4 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

**Аудитын илрүүлэлт:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журам, Төсвийн тухай хуулийг мөрдөж өр төлбөр үүсгэхгүй ажиллах, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсны дараа төлж барагдуулах зөвлөмж өгөв. /ЕБС/

**3.5.6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,495.8 сая, эцсийн үлдэгдэл 2,786.7 сая төгрөг болж, 290.9 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
<i>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</i>	1,642.1	1,642.1	0.0	58.9
<i>Өмнөх үеийн үр дүн</i>	645.7	682.3	36.6	24.5
<i>Тайлант үеийн үр дүн</i>	37.6	298.3	260.7	10.7
<i>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</i>	170.4	164.0	-6.4	5.9
<b>Дүн</b>	<b>2,495.8</b>	<b>2,786.7</b>	<b>290.9</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн 980.6 сая төгрөг болж 297.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 298.3 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан, өмнөх үеийн алдааны залруулга 1.0 сая төгрөгөөр өмнөх үеийн үр дүнд залруулсан нь нөлөөлсөн байна.

### 3.5.7 Орлогын данс

Татварын болон татварын бус орлого 146.5, зээлийн хүүгийн орлого 2.2, үнэ төлбөргүй хүлээн авсан 274.4, туслах үйл ажиллагааны орлого 1.1, борлуулалтын орлого 189.4, татварын бус орлого 8.6, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 1,019.7, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 67.6, нэмэлт санхүүжилтийн орлого 205.0, орон нутгийн төсвөөс санхүүжих 560.8, ЭМД сангаас 63.5 сая нийт 2,538.8 сая төгрөгийн орлого бүрдсэн байна.

### 3.5.8 Зардлын данс

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 1,103.1, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 136.8, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 113.2, хангамж, бараа материалын зардал 69.9, нормативд зардал 161.2, эд хогшил, урсгал засварын зардал 19.5, томилолт, зочны зардал 7.3, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 245.1, бараа үйлчилгээний бусад зардал 195.1, бусад урсгал шилжүүлэг 74.0, улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 33.6, үйл ажиллагааны бус зардалд 81.7 сая нийт 2,248.6 сая төгрөг зардал тайлагнасан байна.

Зардлын данстай холбоотой холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй 0.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

### Аудитын илрүүлэлт:

- Хөдөлмөрийн чадвараа алдсаны акттай 1 ажилтны 11-12 дугаар сарын цалингаас ХХОАТ-ын чөлөөлөлгүй тооцоноос 116.0 мянган төгрөгийг илүү суутгасан зөрчилд төлбөрийн акт тогтоов. /ЕБС 0.1 сая /
- Тэтгэвэрт гарсан 1 ажилтны 9 дүгээр сарын цалин, мөн 1 тэтгэвэрт гарсан ажилтны 9-12 дугаар сарын цалингаас НДШ-ийг энгийн ажилтны хувиар тооцоноос 113.9 мянган төгрөгийг цалингаас илүү, ХХОАТ-ын 8.4 мянган төгрөгийг дутуу, 2.9 мянган төгрөгийг илүү, нийт 125.2 мянган төгрөгийг илүү суутгасан зөрчилд төлбөрийн акт тогтоов. /ЕБС 0.1 сая /

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 09 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 31.5 сая төгрөг, татварын бус орлого 2.5 сая нийт 34.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр татварын орлого 146.5 сая, татварын бус орлого 8.6 сая нийт 155.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын гүйцэтгэл 456 хувиар давсан байна.

#### Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>34.0</b>	<b>155.1</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>31.5</b>	<b>146.5</b>
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>27.5</b>	<b>48.9</b>
Үйл ажиллагааны орлого	1.0	8.7
Хөрөнгийн орлого	16.0	29.5
Шууд бус орлого	10.5	10.8

<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>0.8</b>	<b>68.9</b>
Бууны албан татвар	0.8	1.0
Малд ногдуулах албан татвар	0.0	68.0
<b>Бусад татвар (төлбөр, хураамж)</b>	<b>2.8</b>	<b>1.1</b>
Улсын тэмдэгтийн хураамж	2.5	1.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	0.3	0.0
<b>Газрын төлбөр</b>	<b>0.2</b>	<b>0.1</b>
Газрын төлбөр	0.2	0.1
<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>0.2</b>	<b>27.5</b>
Ан амьтний нөөц ашигласны төлбөр	0.0	27.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.2	0.2
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2.5</b>	<b>8.6</b>
Хүү, торгуулийн орлого	2.5	8.6

Орон нутгийн татварын болон татварын бус орлого төлөвлөснөөс 121.1 сая төгрөгөөр давсан нь ан амьтны нөөц ашигласны төлбөр, малын тоо толгойн албан татварын орлогыг төлөвлөөгүй нь нөлөөлсөн байна.

### **Төсвийн төлөвлөлт**

Тус төсөв захирагчийн 2021 онд татварын орлогыг 31.5 сая, татварын бус орлогыг 2.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 1,894.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,774.0 сая төгрөгийг урсгал зардалд, 67.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 52.5 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангаас олгох зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 49.5, орон нутгийн төсвөөс 591.4, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,007.0, Эрүүл мэндийн даатгалын сангаас 13.3, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 67.6, туслах үйл ажиллагааны орлогоос 1.0 сая нийт 1,074.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,675.1 сая төгрөг буюу 88.4 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдлийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төрийн болон орон нутгийн этгээдээс авсан хандив, тусламж 20.3, дээд шатны төсвийн захирагчаас 33.7, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 152.3 сая нийт 206.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, урамшуулал, шимтгэлд 23.1, байр ашиглалтай холбоотой тогтмол зардалд 18.5, хангамж, бараа материалын зардалд 13.0, нормативд зардалд 103.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 17.4, бараа үйлчилгээний бусад зардалд 5.4, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 22.4, нийт 202.8 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 3.2 сая төгрөгийг авлага үүсгэн төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн, 0.3 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байна.

### **3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс 5 мэдээлэл хуульд заасан хугацаанаас хоцроож, 5 мэдээлэл мэдээлээгүй, мөн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

**Аудитын илрүүлэлт:**

*Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс 33 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 52 мэдээллийг мэдээлээгүй тул албан шаардлага хүргүүлэв. /Цэцэрлэг, ЗДТГ, ЭМТ, ЕБС/*

**33.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Наран сумын Засаг даргад 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	2	-	2	-	-	-	100
Нийт	2	-	2	-	-	-	100

**3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Наран сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 орон нутгийн тусгайн сан, 1 эмийн эргэлтийн сан нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4 дүгнэлт өгч, 3 байгууллага, 2 орон нутгийн тусгай сан нийт 5 газрыг түүвэрт хамруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 15.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3.5 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10.1 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүлэв.

**3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй.

**4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**4.1 Орлогын данстай холбоотой**

4.1.1 Илрүүлэлт: Тус сумын нийт орлого нь 121.1 сая төгрөгөөр буюу 365 хувиар давж биелсэн нь татварын болон татварын бус орлогыг бодиттой төлөвлөгөөгүйтэй холбоотой байна.

4.1.2 Эрсдэл: Төсвийн төлөвлөгөөний үндэслэл хангалтгүй

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн орлогыг төлөвлөхдөө Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу иж бүрэн боловсруулж байх.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

#### **4.2 Данс бүртгэлтэй холбоотой асуудал:**

4.2.1 Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бодит үнэ цэний аргаар толилуулаагүй нийтлэг алдаа гарсан байна.

4.2.2 Эрсдэл: НББ-ийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдэл зөрчигдөх

4.2.3 Өгсөн зөвлөмж: Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

#### **4.3 Данс бүртгэлтэй холбоотой асуудал:**

4.3.1 Илрүүлэлт: Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна.

4.3.2 Эрсдэл: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

4.3.3 Өгсөн зөвлөмж: Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.